

Монгол төрийн алтан аргамжийн бодлого: Эрх зүйн үндэс, уламжлал, шинэчлэлийн асуудалд

Данзангийн Лүндээжанцан

Доктор (Sc.D), профессор, lundeejantsan@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Шихихутаг их сургууль

Нанзаддоржийн Жалбажав*

Доктор (Ph.D), профессор, jalbajav@shihihutug.edu.mn
Монгол Улс, Улаанбаатар, Шихихутаг их сургууль

Оршил

“Монголын нууц товчоо”-ны өгүүлэмжээс эхтэй, найман зууны тэртээ их эзэн Чингис хааны мэргэн ухаан, ухаалаг сэтгэмжийн томьёолол болон үүссэн “Алтан аргамж” хэмээх хэллэг судалгааны ажлын эргэлтэд зүй ёсоор орж ирж байна. Энэ нь дэлхий ертөнцийн өнөөгийн төлөв байдал болон Чингис хаан судлал өргөжиж буй энэ цагийн шаардлагаар нөхцөлдөж байна.

“Алтан аргамж”¹-ийн утга нь найрамдал, найрамдалт харилцаа; тогтсон ёс журам гэсэн утгыг илэрхийлнэ. “Алтан аргамж” нь Их Монгол Улсын үеэс гадаад худалдааны бэлгэдэл; чөлөөт худалдааг дэлхий нийтэд дэлгэрүүлэх, хүн төрөлхтний эдийн засгийн эрмэлзэл, ашиг сонирхлыг холбох; Монгол Улсын эрх ашгийг хамгаалсан, улс хоорондын харилцаанд энх амгаланг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гэж үзэж болно.

Нэг. “Алтан аргамж” хэмээх томьёолол үүсэн гарсан түүхэн цаг үе, орон зай, учир шалтгаан

Монгол угсаатан нүүдэлчдийн цаг тооны зурлагын III жарны улаан гал барс жил (1206) Их Монгол Улс байгуулагдсан билээ. Их Монгол Улсыг байгуулсны дараа төр улсаа төвхнүүлэхэд шийдвэрлэвэл зохих хоёр асуудал босож ирсний нэг нь харийн нутаг дэвсгэрт зугтан гарч, тэндээс шинэ тулгар, нэгдмэл үндэстнийхээ эсрэг тэмцэлд бэлтгэж байсан дайснаа даран сөнөөх, хоёр дахь нь хөрш улсуудтай харилцан ашигтай найрамдалт харилцаа тогтоон, чөлөөт худалдааг хөгжүүлэх явдал байв. Ч.Жүгдэр абугайн бичиж үлдээснээр “Чингис болон түүнийг залгамжлагчид гадаад харилцааг улс төрийн бодлогын чухал хэсэг, төрийн үйл

* Холбоо барих зохиогч

¹ Англиар “Golden Tether Policy”, “Golden Diplomacy” зэргээр орчуулж болно.

ажиллагааны эрхэм үүрэг “Төрийн алтан аргамж” хэмээн үзэж, түүнд онцгой анхаарал тавьж байлаа. “...Алтан аргамж” хэмээх энэ алдарт хэллэг нь угтаа Монголын нууц товчоо (МНТ)-ны 254 дүгээр зүйлд “Чингис хаан алтан аргамжаа Сартуул иргэн (улс)-д яахин таслуулах бүлгээ” хэмээн өгүүлснээс үүдэлтэй билээ. “Алтан аргамж” гэсэн хэллэгийг манай эрдэмтэн, судлаачид өөр өөрөөр томъёолж, бичиж, нийтэлж ирсэн. Тухайлбал:

- Түүхч эрдэмтэн Д.Хүүхэнбаатар агсан, олон улсын эрх зүйч, доктор Г.Төмөрчулуун, олон улсын эрх зүйч, эрдэмтэн Ж.Бор, түүхч, дипломатч Д.Үржинлхүндэв нарын эрдэмтэн судлаач “Алтан аргамж элчин харилцаа гэсэн үг мөн”² гэж томъёолсон байна.
- Судлаач, доктор А.Пунсаг “Алтан аргамж гэдэг бол Чингис хааны томилсон төрийн элч болон хүндэтгэл, харгалзал хүртэх эрх бүхий худалдаачдыг заасан тусгай нэр болно...” гэсэн байна. Мөн тэрбээр “...Монголчууд дээр үед төр засгаа “Алтан төр” хэмээн хүндэтгэн нэрлэж байсан бөгөөд одоо ч гэсэн “Алтан соёмбот төрийн минь сүлд өршөө” гэсэн бэлгэдэл сэтгэхүй хэвээрээ байгаа. “Монголын нууц товчоон”-ы үг утгыг ойлгоход зөвхөн монголчуудын бэлгэдлийн соёл, зүйр үг зэрэгтэй холбон ойлговол жинхэнэ утга нь бэлэн болох юм”³ гэжээ.
- Судлаач, доктор Ж.Заанхүү “Чингис хааны гадаадад хийсэн аян дайн нь дэлхий дахиныг засан тохинуулах зорилготой байсан нь дээрх баримтуудаар тодорхой харагдаж байгаа бөгөөд энэ үзэл санааны гол агуулгыг дараах байдлаар томъёолж болох юм. Найрсаг хөршийн ёсоор эе эвийг сахин хамтран аж төрөх, улс орнуудын хоорондын харилцааг “Алтан аргамж” гэж тайлбарлажээ.⁴
- Судлаач Б.Нагаанбуу “Алтан аргамж” тайлбарыг “Хааны охидыг харь хол аймгийн хан хөвгүүдэд өгч алтан аргамж болгон тэдгээр хан болон худ нарыг гүрний төв бодлогод автуулах хар хайрцгийн чанд бодлого. Дөрвөн хөлт хар тугийн (хүчний бэлгэдлийн) нууц гол түлхүүрийн нэгэн”⁵ гээд цааш нь ХАР ХАЙРЦАГ тайлбарыг “Төрийн бодлогын нууц, төрийн хүчний үндсийг агуулсан хаадын өв ухаан. Хайрцаг гэдэг нь хайртай зүйлээ агуулах сав эрдэм. Авдар гэвэл авах дарах утгад шилжинэ. Энд дурдагдан буй хайрцаг нь дөрвөн хөлт тугийн хаалт хайрцаг хэлбэр гинжин бэхлээс бөгөөд тэр доторх бодлого нь алтан урагтан төр барих, алтан аргамж (хааны охид)-аар татах, тэдний үр алтан ургийг бэхлэх зэрэг бодлого болно”⁶ гэжээ.

Монгол Улсын гадаад харилцааны зохион байгуулалт, арга ажиллагаа, дипломатын өвөрмөц арга барил, ёс дэглэм, хэв заншил ч мөн тухайн үед төлөвшин

² Хайсандай Л. “Монгол төрийн алтан аргамжийн бодлого”, 2021, т-55.

³ Пунсаг А. “Монголын нууц товчоон” ба алт”-// Угсаатан судлал . Tomus XIII. Fasc 12. УБ.,2015. т.124 - 130

⁴ Заанхүү Ж. “Чингис хааны засан тохинуулах үйл ажиллагаа ба даяаршлын асуудал” УБ., 2006. т.117

⁵ Нагаанбуу Н. “Монголын түүх соёлын нэр томъёоны гаргалгаа” УБ., 2005. т.81-82

⁶ Мөн тэнд т.18-19

тогтож байв.⁷ Жишээлбэл: Чингисийн эзэнт төрөөс гадаад бодлогодоо баримталсан зарчмуудыг авч үзвэл:

- Хөрш орнуудтай эрх тэгш харилцах, найрсаг харилцаа тогтоох;
- Хөрш ба бусад улс орноор улсаа хүлээн зөвшөөрүүлэх;
- Гадаад худалдааг хөгжүүлэх;
- Гадаад аюулгүй байдлаа баталгаажуулах зэрэг багтсан байна.

Их Монгол Улсыг хүрээлж байсан улс, аймгууд дотроос худалдаа-эдийн засгийн хувьд нягт уялдаатай, стратегийн ач холбогдол бүхий орон зай нь Хорезм улс байсан бөгөөд тус улс нь өрнө, дорно, өмнө, умрын худалдааны урсгал огтлолцсон төв бүсэд оршиж, олон улсын худалдаанд чухал үүрэг гүйцэтгэж байв. Энэ цаг үед Чингис хаан өөрийн хөвгүүд, мянганы ноёд, цэргийн удирдагчдад даалгавар өгч, тодорхой тооны хүмүүсийг арилжаалах эд барааны хамт Монголд ирсэн худалдаачидтай хамт Хорезмийн шах руу илгээх шийдвэр гаргаж, нийт 500 тэмээний ачаа бүхий 450 орчим хүнтэй томоохон худалдааны цуваа илгээсэн байна. Чингис хааны захидлыг авч явсан элч нар Бухарт хүрч очсон үед Монголын худалдааны баг Отрар хотод ирсэн боловч хотын захирагч Иналчуг тэднийг тагнуул хэмээн буруутган, бүрэлгэх зөвшөөрлийг шах Мухамедээс хүссэн байна. Шах уг саналыг нухацтай шалгалгүйгээр зөвшөөрснөөр Монголын худалдаачид, төлөөлөгчдийн амь насыг олноор нь бүрэлгэж, эд хөрөнгийг хураан авсан нь Монгол, Хорезмийн сөргөлдөөн эхлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг болсон гэж үздэг.

Чингис хаан улс хоорондын худалдааг гадаад харилцааны чухал хэлбэр төдийгүй мэдээлэл олж авах стратегийн хэрэгсэл хэмээн ойлгож байсныг түүхийн эх сурвалжид тодорхой дурдсан байдаг. Чөлөөт худалдаа, арилжааг эрмэлзэх нүүдэлчдийн хандлага нь эрт болон дундад зууны үед суурин иргэншлээс харьцангуй давамгайл байсан бөгөөд үүний үндсэн шалтгаан нь нүүдлийн аж ахуйн бүтээмж, илүүдэл бүтээгдэхүүний нөөцтэй шууд холбоотой юм.

Нүүдэлчдийн ахуй амьдрал, аж төрөх ёс нь суурьшмал нийгэмтэй тогтвортой харилцаа тогтоож мал аж ахуйгаас бусад хэрэгцээт бүтээгдэхүүнийг гадаад худалдаагаар хангах нь байгаль, түүхийн нөхцөлөөс урган гарсан бодит хэрэгцээ байв. Суурин соёл иргэншил бүхий умард Хятадын олон зуун дамнасан бодлого гадаад худалдаанд тогтмол саад учруулж ирсэн бөгөөд уг бүс нутгийг Алтан улс хяналтдаа авснаар Монголын өмнөд чиглэлийн худалдаа, арилжааны боломж улам бүр хязгаарлагдсан байна. Үүнтэй зэрэгцэн дорно ба өрнийг холбосон олон улсын худалдааны гол судал болсон Торгоны их зам дагуу дээрэм, хулгайн шинжтэй үйл ажиллагаа идэвхжиж, худалдаачдын аюулгүй байдал бодитоор алдагдсанаар Монголын хувьд Дундад Азитай тогтоох худалдааны харилцаа саатах, улмаар бараг хаагдах нөхцөл бүрдэж байсан.

⁷ Жүгдэр Ч. “Монголын нийгэм, улс төр, философийн сэтгэлгээний хөгжил”, УБ., 2025, т.151.

Нүүдэлчид мал аж ахуй, ан авыг хослуулсан аж ахуйн хэв маягаар амьдарч, тухайн үеийн Өрнөд Европт тансаг хэрэглээнд тооцогдож байсан махан хүнсийг тогтмол хэрэглэх боломжтой байсан нь бодит баримтаар нотлогддог. Чингис хаан энэхүү эдийн засгийн давуу талыг ашиглан чөлөөт худалдааг өргөн хүрээнд дэлгэрүүлэх зорилго тавьж, худалдааны замыг хамгаалалтад авснаар өмнөд Сибирээс Тангад, Иранаас Солонгос хүртэлх өргөн уудам орон зайг хамарсан харилцааны нэгдмэл сүлжээг бүрдүүлсэн байна.

Чингис хаан байлдан дагуулалтын явцдаа захиргааны шинэ дэг журмыг тогтоож, аюулгүй байдлыг хангах бодлогыг тууштай хэрэгжүүлснээр худалдаачид, аянчдын аюулгүй зорчих нөхцөл мэдэгдэхүйц сайжирчээ. Түүнчлэн гол худалдааны зам, боомтуудад цэрэг байршуулан их хэмжээний эд хөрөнгө тээвэрлэх боломжийг бодитоор баталгаажуулсан нь түүний залгамжлагчдын үед ч үргэлжилсэн билээ.

Судлаач Жак Уэтерфорд бүтээлдээ XIII зууны монголчуудын байлдан дагуулал Орос, Хятад, Солонгос, Төв болон Дундад Азийн болон Энэтхэг үүсэн тогтнох үндсийг тавьсныг онцлоод “1162 онд түүний мэндлэх үед хаяа дэрлэсэн хөршөөсөө бусдын соёл иргэншлийн тухай үл мэддэг...” байсан бол “Чингис хаан 1227 онд бие барахын цагт тэдгээр улсад дипломатын болон худалдааны хэлхээ холбоо тогтсон нь өдгөө хадгалагдсаар байна... Торгоны зам дагуух худалдаа наймааны тархай бутархай, уйтгар төрүүлэм нам гүм суурингуудыг түүхэнд хамгийн том чөлөөт худалдааны бүсүүд болгож өөрчилсөн билээ. Тэрээр бүх хүний албан татварыг бууруулж, эмч, багш, санваартнууд болон сургууль, боловсролын газруудыг татвараас бүрэн чөлөөлсөн юм. ...Тэр олон улсын хуулийг анхлан бий болгож, бүх хүн мөнх хөх тэнгэрийн зарлигт сөгдөн мөргөх болгосон.”⁸ Энэ бүхнээс үзэхэд, хүн амын болон дотоод, гадаадын худалдаачдын хувьд татварын ээлтэй, шударга бодлого баримтлах, чөлөөт худалдаа, наймааг өөгшүүлэн дэмжих, аюулгүй байдлыг нь хангах нь Их Монгол Улсын “Алтан аргамж” бодлогын нэн чухал зорилт нь байжээ. Мөн өөрийн харьяат нар хийгээд эзлэгдсэн улсын иргэдийн шүтэх бишрэх эрх чөлөөнд тэгш шударга, хүндэтгэлтэй хандаж байсан нь “Алтан аргамж” бодлого амжилт олох нэг үндэс болсон.

Чингис хааны дэвшүүлсэн чөлөөт худалдааны үзэл санаа олон улсын хэмжээнд хэрэгжихдээ түүний өөрийн бодож байснаас ч давж олон улсын худалдаа эдийн засгийн байгууллага байгуулах үзэл баримтлалыг бүрдүүлсэн. Тухайлбал: Ил хаан Аргуны санаачилгаар “Худалдааны холбоо” хэмээх байгууллага бий болж өрнөөс дорно зүгт Газрын дундад тэнгисээс Хархорум хүртэл, өмнөөс умар зүгт Басра хотоос Мисир (Египет) хүртэлх өргөн уудам газар нутагт нөлөөгөө түгээж, Ойрх Дорнод болон Дундад Азийн худалдааны онц эрхийг барьж байжээ. Энэ байгууллага нь нэг сая алтан зоосны хөрөнгөтэй, хэдэн зуун мянган адуу, тэмээ, илжиг болон олон тооны хөлөг онгоцтой байсан тухай перс, түрэгийн сурвалж бичгүүдэд

⁸ Жак Уэтерфорд, “Чингис хаан өнөөгийн ертөнцийг үндэслэгч”, УБ., 2012., т.18, 19.

тэмдэглэгдсэн байдаг аж. Судалгаанд дурдсанаар Дундад зууны газар тариалан хөдөлмөр их шаардсан атлаа өгөөж багатай, ихэнхдээ амь зогоох түвшинд байсан бол нүүдлийн мал аж ахуй харьцангуй их баялаг хуримтлуулах боломжтой байсан гэж дүгнэж болохоор байна.

Хоёр. “Алтан аргамж”-ийн эрх зүйн үндэс

Чингисийн төрийн “Алтан аргамж”-ийн бодлого, үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн нарийн зохицуулалттай байсан. Чингис хааны “Их Засаг” хууль нь түүний байгуулсан эзэнт гүрний амьдралд асар их үүрэгтэй байсан ажээ. Монголчуудын болон эзлэгдсэн бусад ард түмний амьдралд бүх талаар нөлөөлж, дэлхий дахины үндсэн гол хууль цаазын үүргийг удаан хугацаагаар гүйцэтгэж иржээ. Тухайлбал: “Оросын Вант улсуудын хувь заяаг гартаа атгаж байсан Алтан ордны улсад энэ хуулиас өөр бичигдсэн хууль байгаагүй юм гэж” Оросын эрдэмтэн В.А.Рязановский бичсэн байна. Их Засаг хууль Цагадайн Улсад XV-XVI, Зүчийн Улсад XVI зуун хүртэл мөрдөгдөж байв.

Их Засаг хууль хийгээд Их Монгол Улсын төрийн гадаад бодлогод хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, гадаадын халдлага довтолгооноос сэргийлэх, өрнө, дорнын улс оронтой улс төр, эдийн засаг, соёлын хэлхээ холбоогоо өргөтгөх, мэдээллийн солилцоог идэвхжүүлэх, улс орноо засан тохинуулах гээд хожим хойчдоо төрийн “Алтан аргамж” бодлогын олон санаа шингэжээ. Чингис хаан Их засаг хуульд Монголын газар нутгаар дайран өнгөрч буй худалдааны жингийн цуваа нь дайсан орных байсан ч довтолж үл болох мөн тэдгээр худалдаачдыг орд өргөөгөөрөө дайруулан дэлхий дахинд болж буй бүхий л үйл явдлыг худалдаачдын ярианаас сонсож “мэдээлэл цуглуулдаг”, худалдаачдын аюулгүй байдлыг хангах тухай агуулгуудыг өргөнөөр багтаасан байдаг.

Худалдаачин, элчин төлөөлөгчдийн эрх ямба, аюулгүй байдлыг баталгаажуулах, халдашгүй байдлын “Гэрэгэ” тэмдэг олгох зэрэг нь өнөөгийн дипломат ёсны соёлын төлөвшилтөд монголчуудын оруулсан үнэтэй хувь нэмэр юм.

Судлаач Ц.Минжин Гэрэгэг тодорхойлохдоо “Монголын элчийн бэлгэдэл болсон “Гэрэгэ” нь тэдний эрх зүйн үр дагаврыг бий болгох үндсэн баримт бичиг нь болж байлаа. ...“Гэрэгэ” нь орчин цагийн дипломат паспорт, итгэмжлэх жуух бичгийн үүргийг гүйцэтгэж, түүнийг өвөртлөн яваа “зарлигийн элч”-ийг зэрэг дэвээс нь хамаарахгүйгээр өнгөрөн явах газарт ижил хүндэтгэл үзүүлдэг нь тэд бүгд хаан эзний сонгон явуулсан итгэлт хүмүүс бөгөөд үг хэл хурц, ой цээж цэцэн цэлмэг агаад, тусгайлан бэлдэж харь хэл сурган элч болгон хэрэглэхдээ дамжуулах мэдээ занги, хэлүүлэх үгийг шүлэглэн цээжлүүлж явуулдаг нь дайн тулаан элбэг байсан тухайн цаг үеийн нөхцөл байдалд нэн зохицсон бодлого байв. Учир нь элч эс уравбаас нууц задаршгүй билээ, түүнээс гадна элчийг хамгаалан явах тусгай цэргийн хамгаалалтыг хүртэл гаргаж байжээ. Их Монгол Улс, Монголын эзэнт гүрний хаад төрийнхөө

түшээд, эрхтэн, дархтан, гавьяатан, төр, цэргийн элч, худалдаачин нартаа итгэмжлэн олгодог “Гэрэгэ” нь хууль эрхэмж, соёл иргэншил, ёс суртахуун, гоо зүй, элчин харилцаа, төр цаазын зэрэг олон талт ойлголтын цогц бэлгэдэл, эрхийн баталгаа нь болж өгдөг байна”⁹ гэжээ.

Үнэндээ “Элчин төлөөлөгчдийн халдашгүй дархан эрхийн тухай хэм хэмжээг зөрчихөөс Монголчууд чанд цээрлэж байсан агаад харийн хүнийг алах явдлыг гэмт хэрэг гэж үздэггүй байсан эртний болон дундад эртний ёсыг өөрчилсөн Чингис хаан, түүний засаг хуульд хожмын дипломатууд хөшөө босгох хэрэгтэй”¹⁰ хэмээсэн Л.М.Гумилев агсны дүгнэлттэй бид санал нэгтэй байна.

“Их Монгол улс, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын төрийн бодлого нь тухайн үеийн төрт улсуудын идэвхтэй бүс байсан Евроазийн нутаг дэвсгэрт тархан үйлчилж байснаараа өргөн цар хүрээтэй байжээ”¹¹ гэж үзвээс Их засаг хуулийн үйлчлэл мөн энэ хүрээнд баттай үйлчилж байсан гэж хэлж болно.

Гурав. “Алтан аргамж” бодлогын үндсэн арга хэрэгсэл

Монголчуудын байлдан дагуулал нь нүүдэлчдийн дунд анх үүссэн чөлөөт зах зээл, чөлөөт худалдааны үзлийг дэлхий дахин түгээсэн. Өөрөөр хэлбэл: тухайн үеийн Монгол Улс оюун санааны болон нийгэм-эдийн засгийн харилцааны хөгжлийн хувьд Дундад Ази болон Европоос түрүүлж байжээ.

Монголд төмөрлөгийн үйлдвэрлэл сайн хөгжсөний дээр реэкспортыг гаргууд хийж байв. Тухайн үеийн Монголын аж ахуй торгоноос бусдыг үйлдвэрлэдэг байв. Түүнчлэн Монголын мал аж ахуй мах, сүү, ноос, ноолуур, хялгас, хөөврөөс гадна зүтгүүрийн мал ихээр бий болгодог учир газар тариалангаас хавьгүй баялаг байсан аж. Тухайлбал:

- Бусад улс оронтой нийтлэг ашиг сонирхлоо эрхэмлэн найрамдах, нөхөрлөх, хамтын ажиллагаа, түншлэл тогтоох, энэ хүрээнд худалдаа наймааны таатай орчин нөхцөл бүрдүүлэх;
- Чөлөөт худалдаа арилжааг хөхүүлэн дэмжих, худалдаачид, худалдааны замын аюулгүй байдлыг хангах, хамгаалах;
- Өөрийн орны эсрэг бусад улс оронд эвсэх нэгдэх аюулыг сэрэмжлэн зайлуулах;
- Дайсагч (өрсөлдөгч) этгээдүүдийн сул тал, өөр хоорондын нь зөрчил, тэмцлийг ашиглах, дайсагнагч нэг улсын эсрэг нөгөөтэй нь хамсах, эвсэх;

⁹ Минжин Ц. “Гэрэгэ нь эрх мэдлийн баталгаа болох нь” -//“Хижрийн 7-8, нийтийн XIII-XIV зууны азийн соёл иргэншлийн үнэт зүйлс – Гэрэгэ” ОУЭШХ. УБ., 2015.Х.28-29.

¹⁰ Бор Ж. “Билгүүн дипломатч Чингис” УБ.,1994. т.38

¹¹ Минжин Ц. “Их засаг”-ийн уламжлал” /Юань улсын жишээн дээр/-//“Чингисийн Монголын Хууль Цаазын уламжлал ба “Төвд хүрхүүн Журам” ОУЭШХ УБ., 2012.05.24-26

- Бүр болохгүй аваас айлган сүрдүүлэх, ов, заль мэх хэрэглэх, хүч түрэх, хэрэглэх (номхотгох, түвшитгэх аян дайн) зэргийг нэрлэж болно.

Дүгнэж үзвэл нүүдэлчдийн эрхлэх аж ахуй болон сэтгэлгээний онцлогийн нэг гол бүтээл нь чөлөөт зах зээл, чөлөөт худалдааны үзэл ажээ. Тэдний туйлын хүслэн бол хөл хүрэх газраа очиж чөлөөтэй худалдаалах эрмэлзэл байв. Тиймээс нүүдэлчдийн түүх бол бас чөлөөт худалдаа, чөлөөт зах зээлийн төлөө тэмцлийн түүх гарцаагүй мөн. Нүүдэлчдийн амьдралын байнгын хөдөлгөөнт хэв маяг нь алт, мөнгө, эрдэнийн зүйлс зэргийг их хэмжээгээр хуримтлуулан хадгалах боломжгүй болгож байв. Иймээс тэд элдэв баялгаа авч нүүхэд тохиромжтой болгох аргыг эрэлхийлсний дүнд алтан баталгаа бүхий цаасан мөнгө бий болгожээ.

Чингис хаан гадаад худалдаагаар дамжуулан олон улсын найрсаг харилцааг бэхжүүлж, үндэснийхээ аюулгүй байдлыг хангахад ямагт анхаарал тавьж байсан бөгөөд уг зорилгодоо хүрч чадсан юм. Тэрбээр дэлхий нийтийн энх тайвны асуудлыг анх үүсгэн тавьж, өөрийнх нь хэлснээр “эцсийн тэнгис” хүртэлх газрыг энх шударга болгох туйлын эрмэлзэл бүхий өргөн цар хүрээтэй бодлого явуулж байв. Ингэж дэлхийн хэмжээнд сэтгэж, дэлхийг өөрийн оюунд багтааж чадсан энэхүү үзэл баримтлалын гол зангилаа нь олон улсын худалдааны үйл хэрэгт төвлөрч байв. Энэ бодлого бол чөлөөт худалдааг дэлхий нийтэд дэлгэрүүлэх, хүн төрөлхтний эдийн засгийн эрмэлзэл, ашиг сонирхлыг холбож өгөхөд чиглэж байжээ. Чингис хаан чөлөөт худалдааны шинэ үзэл, шинэ үйлс, шинэ ухамсрыг дэлхий дахинд авчирч, Өрнө-Дорныг холбосон худалдаа харилцааны гол суваг болсон “торгоны зам”-ын аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарал тавьж байжээ. Үүнд гадаад худалдаа “Алтан аргамж” нь болсон юм. Зарим судлаачийн тэмдэглэснээр олон улсын түгээмэл эрх зүй, түүний дотроос дайны ёс цааз, дипломатын эрх зүй, эдийн засгийн харилцааны дэг журам, хэм хэмжээнд холбогдох олон чухал зарчмыг дундад эртний Монголчууд Чингис хааны хэрэгжүүлж байсан бодлогоор дамжуулан дэвшүүлж гаргасан байна.

Дөрөв. “Алтан аргамж”-ийн уламжлал, шинэчлэлийн тухайд

Их засгийн “Алтан аргамж”-ийн үзэл санаа нь Их Монгол Улс, Монголын эзэнт гүрэн, Богд хаант Монгол Улс, БНМАУ, Монгол Улс гээд Монголын тусгаар улсын статустай оршин тогтнож ирсэн. Түүхийн бүх үед төрийн хуулийн бодлого, үйл ажиллагааны чиг баримжаа нь монголчуудын үндэсний ухамсар, ой санамжийн үнэт зүйлс, уламжлал болж иржээ. Тухайлбал: Их Юань улсын хууль цаазын бичиг (1271 он); “Ертөнцийг засах магад хууль” буюу “Хаан төрийн ертөнцийг засах магад хууль” (1312 он); “Их Юанийн нэвтэрхий хууль” (1322 он); Улс төрийн бутралын гэж нэршигдсэн (ойролцоогоор 1370-1660 аад он) үеийн “Монгол, Ойрадын хууль” (1640 он); “Алтан хааны цаазын бичиг”; БНМАУ-ын Үндсэн хууль (1924, 1940, 1960)-д улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэх, улс түмний энх тайван аюулгүй байдлын төлөө энхийг эрхэмлэгч

бодлогын зүйлүүд ямар нэгэн байдлаар тухайн цаг үеийн нэр томъёогоор тусаж монголын төрийн гадаад бодлогын “тулганы чулуу” нь болж иржээ.

Түүх цадигт “Монгол-Ойрадын хууль”, “Дөчин дөрвөн хоёрын их цааз” (1635он) зэргээр тэмдэглэгдсэн төрийн хууль цаазын нэн чухал энэ сурвалжид улс үндэстнийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэн эв нэгдлийг эрхэмлэх, төрт ёс, харьяатын ёсыг бэхжүүлэх шарын шашны нөлөөг өргөх санааг тод тусгажээ. Цаазын бичгийн эхний зүйлд “Аливаа хүн энэ төрийг эвдэн их аймаг улсыг алж талбаас Монгол, Ойрад хоёр нийлээд түүний ганц биеийг нь тавиад биш бүхнийг авч, тавигчид хагасыг өгөөд үлдсэнийг нь хоёр хагас хуваан авах болов. Захын цөөн хүн аймаг улсыг талж авбаас зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу аваад, аль авсныг нь цөм хариулаад хүн мал эдийг нь ор өгөх болов”¹² хэмээн бичжээ.

XX зуун Монголын түүх, тусгаар тогтнолын төлөө монголчуудын тэмцлийн түүхэнд онцгой байр суурь эзэлнэ. Үүний тод жишээ нь: 1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд сэргээн байгуулагдсан Монголын төр 200 гаруй жилийн туршид Монголыг гадаад ертөнцөөс битүүмжлэн хязгаарлах Манжийн бодлогын уршиг болох эрин зууны хоцрогдлыг арилгах, улсаа бэхжүүлэхийн тулд төрийн байгуулалтаа төлөвшүүлэх, эдийн засгаа хөл дээр нь босгох, бас ч цэргийн хүчээ бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж байжээ.¹³ Гэвч Богд хаант Монгол Улсын тусгаар тогтнол хоёр их хөршөөс үлэмж хамааралтай, ёстой “хутганы ирэн дээр” байв. Чухам энэ цаг үеийг монголчуудын төрийн “Алтан аргамж”-ийн бодлогоо сэргээн улс үндэстнийхээ эрх ашгийг эрх биш эрхэмлэн “өөрийгөө хамгаалан үлдэх, Монголыг нэг улсын доторх бус олон улсын субъектийн түвшинд хүргэхийг зорьж” нөр их хичээсэн, тэсвэр тэвчээр, ур ухаан зарсан үе байв.¹⁴ Үүний үрээр зарим судлаачийн үзэж буйгаар 1915 оны гурван улсын (Орос, Хятад, Монгол) гэрээгээр Монгол Улс 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнол, бие даасан байдлаа хязгаарлуулсан ч хоёр хөршөөрөө эвдүүлэхгүй байх олон улсын баталгааг бүрдүүлсэн” гэж үздэг байна.¹⁵ Тухайн цаг үед гурван улсын гэрээгээр тогтоосон Монголын байдлыг монголын төрийн зүтгэлтнүүд хэрхэн ойлгож байсныг дараах баримтаас харж болно. Үүнд: Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т өгүүлэхдээ: “хүчирхэг нь буурайгаа дарлан элдэв эрх ашгийг булаан эзэрхэгийг хичээх нь олон улсын нийтэд бүхий дадсан суртал мөн тул эс болгоомжилбоос эс болох... Энэхүү гэрээ бичгийн гол утга болбоос бидний улс хэдий Думдад улсын хэмжээтэй эзэрхэгийг хүлээн зөвшөөрсөн боловч Думдад улсаас бидний дотоод засгийн буй бүхий хэрэгт оролцох эрх огт үгүй” хэмээн тэмдэглэсэн байна. Үүнийг Монголын Засгийн газрын гурван улсын гэрээний

¹² Болдбаатар Ж., Д.Лүндээжанцан” Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал., УБ., т.129

¹³ Монгол Улсын түүх,УБ.,2017. т.329.

¹⁴ Батсайхан.О, “Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд” УБ., 2014. т-94-95/

¹⁵ Мөн тэнд

талаар баримталсан албан ёсны бодлого, байр суурь гэж үздэг байна.

Нөгөөтээгүүр, 1921 оны ардын хувьсгал, 1924 оны Улсын анхдугаар Их хурал БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг батлан Үндсэн хуулиараа Монгол Улсыг Бүрэн эрхт Бүгд найрамдах Улс болгон тунхагласан нь монголчуудын төр улсынхаа тусгаар тогтнолын төлөө тэмцлийн шинэ үеийг эхлүүлжээ. Монголын төр улсын гадаад харилцааны түүхэн шинэ үе буюу БНМАУ-ын үе ийнхүү эхэлсэн гэж үздэг. Энэ түүхэн гэмээр цаг үеэс улсын тусгаар тогтнолыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх (de facto-“тухайлан олгогдох” улмаар de jure-д хүрэх)-ийн төлөө тэмцлийн үе буюу 1924-1961 он хүртэлх үеийг онцгойлон авч үзэх учиртай. Энэ үед Монгол Улс нэг талаас төр улсын тусгаар тогтнолын үзэл санааны үндэс болж байсан үндэсний эрх ашгаа дээдэлсэн үндэсний ардчилсан үзэл баримтлалаас монгол хүмүүний мөн чанарт харш ангич үзэл суртал, нийгмийн өөр өөр байгуулал бүхий хоёр туйлт ертөнцийн тэмцлийн эргүүлэгт автсан дотоод, гадаад бодлого баримталж алдаж эндэж, гарз хохирол чамгүй амссан ч хүчинд автан аялдан дагах арга чаргын цаана улс орныхоо тусгаар тогтнолыг баталгаажуулах санаа зорилго агуулагдаж байв.

Нэг үгээр хэлэхэд “Алтан аргамж” суларсан ч тасраагүй, түүний оюуны эх нь болсон монгол хүмүүний эх оронч үзэл, үндэсний ухамсар бахархал, итгэл үнэмшил “ханцуй дотор” нь лугшсаар байсан юм. Монгол Улс 1961 онд олон улсын хамтын нийгэмлэг-НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олон улсын тавцанд баталгаажуулсан юм. Тусгаар тогтнолоо баталгаажуулах нь монголын ард түмэн, төр засгаас нөр их ур ухаан, тэсвэр тэвчээр, хүч чармайлт шаардсан амаргүй зам байв.¹⁶

Эдүгээ газар зүйн өвөрмөц байршилтай, хоёр их гүрний дунд орших Монгол Улс нь аюулгүй байдлаа хангахын тулд хоёр хөрштэйгөө стратегийн түншлэл тогтоон тэнцүү харилцах, бусад улс орнуудтай “гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлэх зарчим баримталж байна.¹⁷ Дээрх агуулгыг нэгтгэн дүгнэвэл:

¹⁶ Улс үндэстэн, тусгаар тогтнол хэмээх ойлголтууд нь “1648 оны Вестфалын гэрээний үед буй болсон төр улсын орчин үеийн системийг бүрэлдүүлэх талаар дэвшүүлсэн санаатай холбоотой” ажээ. Вестфалийн энхийн гэрээ нь 1618-1648 онд Ариун Ромын эзэнт гүрний болон Европын бүхий л орнуудыг их бага хэмжээгээр хамарсан хэд хэдэн дайныг нэгтгэсэн “Гучин жилийн дайны” төгсгөлд Европын их гүрнүүдийн хооронд байгуулагдсан бөгөөд олон улсын нийтийн эрх зүйн хөгжилд чухал үйл явдал гэж үздэг. Улс гүрний тэгш бүрэн эрхийн зарчим, нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх зарчим, шашин шүтэх эрх чөлөөний зарчим, дипломат харилцааны зарчим, хүчний тэнцвэрийн зарчим зэрэг эрх зүйн орчин бүрдүүлэх үндэс суурийг тавьсан ач холбогдолтой. Вестфалийн энхийн гэрээ нь улсын бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлын зарчмыг тогтооход тусалсан. Өөрөөр хэлбэл: улс бүр өөрийн нутаг дэвсгэрийг гаднын хүчний хөндлөнгийн оролцоогүйгээр удирдах эрхийг хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр улс орнуудыг олон улсын харилцааны үндсэн оролцогч гэж үздэг орчин үеийн үндэстэн - төрийн тогтолцооны үндэс суурийг тавьсан юм.

¹⁷ Гуравдагч хөршийн бодлого нь Монгол Улсын гадаад бодлогын нэгэн илэрхийлэл бөгөөд ОХУ, БНХАУ-аас бусад хөгжингүй улс оронтой түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого. “Монгол Улсын гадаад орчинг тодорхойлоход хоёр хөршөөс гадна гуравдагч хөршүүд манай улсын ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн баталгаа болсоор байна”. Улсын Их Хурлын 2011 оны хоёрдугаар сарын 10-ны өдрийн тогтоолоор шинэчлэн батлагдсан Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улсын улс төрийн гадаад бодлогын нэг хэсэг нь “Америк, Япон, Европын холбоо, Энэтхэг, Өмнөд Солонгос, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж

1. “Алтан аргамж” хэмээх нь улс үндэстэн бүрийн амьдралын амгалан тайван бөгөөд гачигдал, хомсдолгүй амьдрах гадаад таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын хамгийн уян хатан хэрэгсэл, монголчуудын гадаад худалдаа, ухаалаг гадаад бодлогын бэлгэдэл мөн ажгуу.
2. Орчин үеийн монголын төрийн “Алтан аргамж”-ийн бодлогын үндсэн (зарчим) зүйлүүдийг бид:
 - Улс, үндэстнийхээ эрх ашгийг эрхэмлэх;
 - Төрийн гадаад бодлогын үндсэн зорилго, зорилтууд, суурь зарчмууд хуульчлагдсан байх;
 - Олон улсын харилцааны түгээмэл суурь зарчмуудыг тууштай баримтлах;
 - Бусад улс орон, байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээрийг хүндэтгэн сахих, хүлээсэн үүрэгтээ хариуцлагатай үнэнч байх;
 - Олон улсын харилцааны дипломат ёс, горим журмыг хүндэтгэн сахих гэж тодорхойлж байна.
3. Төрийн “алтан аргамж”-ийн бодлогын гол үр дүн нь:
 - Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, түүний баталгаажилт-де-юре, ялангуяа эдийн засгийн бие даасан байдал;
 - Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын нэр хүнд, байр суурь;
 - Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөний баталгаажилт юм.

Нүүдлийн соёл иргэншлийн гол тээгчдийн нэг нь болсон монголчууд хүн төрөлхтний түүх, дэвшил хөгжилд үлэмж хувь нэмэр оруулсан ард түмэн билээ. Тухайлбал: Чөлөөт худалдааны үзэл санааг Өрнө, Дорнодод түгээж, Ази, Европыг холбосон алдарт “Торгоны зам”-ыг гаргасан бөгөөд тэр нь Өрнө, Дорнын соёлын солилцоо болон түүний харилцан холбоотой хөгжилд өргөн боломжийг нээсэн явдал юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганы нэгдсэн хуралдаан (2001 оны 11 дүгээр сар)-аар хэлэлцсэн Соёл иргэншлүүдийн хоорондын хэлэлцүүлгийн нийтлэг хөтөлбөрт үүнийг бататган бичсэн нь¹⁸ монголчуудын хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан хувь нэмрийг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч буй нэгэн нотолгоо гэж үзнэ.

Эх сурвалжийн жагсаалт

Баасанхүү Г., Д.Оюунсүрэн нар. Олон улсын харилцааны үндэс ба даяаршил. УБ., 2016.
Батбаяр Ц., Д.Лүндээжанцан. 1945 оны Чөлөөлөх дайн: Монгол ба дэлхий дахин. УБ., 2025.

заасан байдаг.

¹⁸ “Нүүдлийн соёл иргэншлийн баялаг байдал, бүх хэлбэрийн соёл иргэншлийн харилцааг бэхжүүлэхэд түүний гүйцэтгэсэн үүргийг, Нүүдлийн соёл иргэншил нь Ази, Европ тив дэх нийгмүүдэд харилцан нөлөө үзүүлж, хүний үнэлэмжийг жинхэнээр харилцан солилцож өрнө болон дорнын нөлөөг уусган авсан болохыг хүлээн зөвшөөрч, Нүүдэлчдийн хүчтэй тогтвортой соёл нь худалдаа наймааны өргөн сүлжээг хөгжүүлэх, засаг захиргаа, соёл, шашны болон арилжааны томоохон төвүүдийг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг мөн хүлээн зөвшөөрч” гэж бичсэн байна.

- Батсайхан О. Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд /1911-1946/. УБ., 2014.
- Болдбаатар Ж., Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2021.
- Бор Ж. Монгол хийгээд Евразийн дипломат шаштир II., УБ., 2005.
- Бор Ж. Монголын дипломат товчоон. УБ., 2020.
- Бор Ж. Билгүүн дипломатч Чингис УБ., 1994. т.38
- Жак Уэтерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан. УБ., 2012.
- Жүгдэр Ч.. Монголын нийгэм, улс төр, философийн сэтгэлгээний хөгжил., УБ., 2026.
- Заанхүү Ж. “Чингис хааны засан тохинуулах үйл ажиллагаа ба даяаршлын асуудал” УБ., 2006.
- Лүндээжанцан Д. Монгол хаадын захидал, монголын төрт ёс, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2022.
- Минжин Ц. “Гэрэгэ нь эрх мэдлийн баталгаа болох нь” -//“Хижрийн 7-8, нийтийн XIII-XIV зууны Азийн соёл иргэншлийн үнэт зүйлс – Гэрэгэ” ОУЭШХ. УБ., 2015. т.28-29.
- Минжин Ц. “Их засаг”-ийн уламжлал” /Юань улсын жишээн дээр/-// “Чингисийн Монголын Хууль Цаазын уламжлал ба “Төвд хүрхүйн Журам” ОУЭШХ УБ., 2012.05.24-2.
- Минжин Ц. “Алтан аргамжийн бодлого ба үндэсний аюулгүй байдал” -//“Монголын энх тайван ба түүхэн туршлага” сэдэвт олон улсын монголч эрдэмтний XII их хурал. ОУЭШХ. УБ., 2023.VIII.09-14.
- Монгол Улсын гадаад бодлогын хөх ном. 2019.
- Монгол Улсын түүх., УБ., 2006.
- Монгол Улсын түүх., УБ., 2017.
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014.
- Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2014.
- Монголын нууц товчоо.Ц.Дамдинсүрэнгийн орчуулга.,УБ., 1947/1996/.
- Монголын эх түүх, 5 боть, УБ., 2014.
- Нагаанбуу Н. “Монголын түүх соёлын нэр томъёоны гаргалгаа” УБ., 2005
- Пунсаг А. “Монголын нууц товчоон” ба алт”-// Угсаатан судлал. Tomus XIII. Fasc 12. УБ., 2015
- Хайсандай Л. Монгол төрийн алтан аргамжийн бодлого. УБ., 2022.

Хууль тогтоомжийн актууд:

- Монгол Улсын Үндсэн хууль 2005.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010.
- Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 2012.

The Mongolian State's Golden Tether Policy: Legal Foundations, Traditions and Reform Issues

Lundeejantsan Danzan

Doctor (Sc.D), professor, lundeejantsan@gmail.com
Shihihutag University, Ulaanbaatar, Mongolia

Jalbajav Nanzaddorj*

Doctor (Ph.D), professor, jalbajav@shihihutug.edu.mn
Shihihutag University, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author

Received: December 5, 2025 | Accepted: December 23, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.